



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 01 сарын 11 өдөр

Дугаар А/13

Ховд

Үзэсгэлэн худалдаа зохион байгуулах тухай

Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.3.5.1 дэхь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Хаврын өнгө-2019" үзэсгэлэн худалдааг 2019 оны 01 дүгээр сарын 28-30 ны өдрүүдэд аймгийн төвд зохион байгуулсугай.

2. "Хаврын өнгө-2019" үзэсгэлэн худалдааг угтсан ажлыг зохион байгуулж, сум, орон нутгийн аж ахуйн нэгж, байгууллагууд болон иргэдийг өргөнөөр оролцуулах ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн

дарга:

Т.Жаргалсайхан

- Аймгийн Засаг даргын орлогч

Гишүүд:

С.Гантөмөр

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр гүйцэтгэгч

Г.Гончигсүрэн

- Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга

Ц.Ганданповрон

- Жаргалант сумын Засаг дарга

Л.Билэгдэмбэрэл

- Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга

П.Эрдэнэчулуун

- Мэргэжлийн хяналтын газрын дарга

Б.Эрдэнэцэцэг

- Стандартчилал хэмжилзүйн хэлтсийн дарга

С.Ариунжаргал

- Хөгжимт драмын театрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Д.Баярмаа

- Хөгжил политехник коллежийн захирал

Г.Цэдэнбал - Биеийн тамир спортын газрын дарга

Ц.Буянтогтох - Хүнс, хөдөө аж ахуйн газрын албаны дарга бөгөөд хүнсний үйлдвэрлэл, технологи, худалдаа, нийтийн хоолны асуудал хариуцсан мэргэжилтэн

Д.Эрдэнэдорж - Хүнс, хөдөө аж ахуйн газрын Жижиг, дунд үйлдвэр, хоршоо ахуй үйлчилгээний асуудал хариуцсан мэргэжилтэн

Б.Хишигзаяа - Аймгийн Засаг даргын Тамгын газрын хэвлэл мэдээллийн ажилтан

Б.Ганзориг - Аймгийн ХАҮТанхимын дарга

Нарийн бичгийн дарга:

Н.Гэрэлмаа - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

3. Үзэсгэлэн худалдаа зохион байгуулах ажлын төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг өргөнөөр оролцуулан ажиллахыг ажлын хэсгийн дарга /Т.Жаргалсайхан/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ